

Ажлын хуудас №1а

1. Дэлхий хэрхэн хөдөлж байна вэ? \дэлхийн хөдөлгөөнийг ажиглуулах\

.....
.....
.....

2. Дэлхий нарыг цагийн зүүний эсрэг эргэдэг юм болов уу? Цагийн зүүний дагуу эргэдэг юм болов уу?

.....
.....
.....

3. Мөн дэлхий тэнхлэгээ аль чиглэлд эргэдэг юм бэ?

.....
.....

Туршилт хийлгэх: Сурагчид багаараа зааврын дагуу туршаад үзэн ярилцаж, дүгнэлт гаргана. Сурагчид хосоор ажиллана. Нэг нь чийдэн барьж өгнө. Нөгөө сурагч нь глобусыг зааврын дагуу эргүүлж ажиглана. Туршилтын үр дүнг тэмдэглэж, ярилцана.

Туршилтын заавар:

1. Газрын зураг дээр Монгол улсыг олж таван хошууг наах
2. Цагийн зүүний дагуу аажмаар эргүүлээд Монголд хаанаас нар мандаж, хаана жаргаж байгааг ажиглаад ажлын хуудсанд тэмдэглэх
3. Дахин цагийн зүүний эсрэг аажмаар эргүүлээд туршилтыг давтан хийж тэмдэглэх.

Сурагчдын хүрэх ёстой үр дүн, зөв хариулт:

- Дэлхий нарыг тойрон хөдөлдөг бөгөөд өөрийн тэнхлэгээ давхар эргэдэг.
- Дэлхий нарыг цагийн зүүний дагуу эргэдэг бөгөөд өөрийн тэнхлэгээ цагийн зүүний эсрэг эргэдэг.

Ажлын хуудас №1б

4. Өдөр шөнө яагаад солигддог вэ?

Туршилт хийх: Сурагчид багаараа зааврын дагуу туршаад үзэн ярилцаж, дүгнэлт гаргана. Сурагчид хос хосоор ажиллана.

Туршилтын заавар:

1. Монгол орныг олоорой
2. Нэлээд зайнаас гар чийдэнг гэрэлтүүлэх
3. Глобусыг тэнхлэгийн дагуу аажмаар эргүүлээд ажиглах
4. Ажигласан зүйлээ ажлын хуудсанд тэмдэглэх
5. Багаараа хамтран ярилцаад дүгнэлтээ гаргах.

Сурагчдын хүрэх ёстой үр дүн, зөв хариулт:

- “Дэлхий нарыг тойрон эргэхдээ өөрийн тэнхлэгээ давхар эргэдэг учраас дэлхийн нар тусдаг хэсэгт өдөр болж, нар тусаагүй байгаа хэсэгт шөнө болдог юм байна” гэсэн хариултад хүрнэ.

Сурагчдын өөрийгөө сорих даалгавар:

1. Дэлхий тэнхлэгээ хэдэн цагт бүтэн эргэдэг вэ?
А. 12 цаг Б. 24 цаг В. 48 цаг
2. Дэлхий хэдий хугацаанд нарыг тойрон эргэдэг вэ?
А. 30 хоног Б. 250 хоног В. 365 хоног
3. Өдөр шөнө яагаад солигддог вэ?
4. А. Нар дэлхийг тойрон эргэдэг учраас
Б. Дэлхий нарыг тойрон эргэдэг учраас
В. Дэлхий өөрийн тэнхлэгээ давхар эргэдэг учраас
5. Дэлхий нарыг аль чиглэлд эргэдэг вэ?
А. Цагийн зүүний дагуу Б. Цагийн зүүний эсрэг
6. Дэлхий тэнхлэгээ аль чиглэлд эргэдэг вэ?
А. Цагийн зүүний дагуу Б. Цагийн зүүний эсрэг